

БНХАУ-ын зээл, тусламжийн бодлого ба Монгол Улс

Д.Батжаргал

*Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн
Хятад судлалын салбар*

ABSTRACT

China's foreign aid policy initially aimed to break away from isolation and join the international community, but since the beginning of the 21st century, it can be said that it has become more systematic and active in terms of policy approach and scope. In recent years, foreign academics and researchers have discussed the fact that China has set certain conditions in its foreign aid policy, such as political, indirect, derivative, and variable. Therefore, it is intended to investigate whether there are any conditions for the foreign aid provided by China to Mongolia, and to give an opinion on what to do in the future.

Keywords: *Chinese foreign aid policy, Mongolian-Chinese relations, Grants, Interest free loans, Concessional loans.*

Гадаад тусламж (Foreign Aid) гэдэг нь аль нэг улс буюу олон улсын байгууллагаас тодорхой нэг улс ба хүмүүст зориулан шилжүүлж буй мөнгө, бараа, үйлчилгээг хэлнэ. Гадаад тусламж нь эдийн засгийн, цэргийн болон хүмүүнлэгийн зэрэг олон хэлбэрүүдтэй бол тусламжийг хүлээн авагч улсын хувьд нэг талаар санхүүгийн чухал эх үүсвэр болдог ч нөгөө талаар Засгийн газрын гадаад өрийг нэмэгдүүлж байдаг. Иймээс “Өрийн удирдлагын тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох бүрэн эрхийг УИХ-д хуульчлан олгосон бий.

Монгол Улс ямар нэгэн дэд бүтцийн бүтээн байгуулалт хийхэд хөрөнгийн эх үүсвэр дутагдаж, янз бүрийн шалтгаанаар гадаадын тусламж, түүний дотор урт хугацааны зээлийг бусад улс, олон улсын байгууллагаас авахад хүрдэг байна. Монгол Улсын төсвийн урсгал тэнцэл сүүлийн арав гаруй жил өндөр алдагдалтай байж, энэхүү алдагдлыг нөхөхөд гадаадын шууд хөрөнгө оруулалт, зээл болон бусад улс, олон улсын байгууллагаас санхүүжүүлэлт хүсдэг. Манай улсад хамгийн их хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийг Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд, БНХАУ, Япон зэрэг улсууд үзүүлдэг (Диаграмм 1).

2018-2020 онд гадаадаас авсан нийт зээлийн 35.8 хувийг Азийн хөгжлийн банкнаас, 20.3 хувийг БНХАУ-аас, 15.3 хувийг Япон улсаас авч, зээлийн 44.1 хувийг төсвийн дэмжлэг буюу төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулсан байна.

Диаграмм 1. Авсан гадаад зээл, тусламжийн байдал



Эх сурвалж: Төрийн аудитын байгууллага (2022 он)¹

График 1. Нэгдсэн төсвийн тэнцэл ба төсвийн алдагдлыг нөхөх зээлийн ашиглалт


Эх сурвалж: Төрийн аудитын байгууллага (2022 он)²

Төсвийн алдагдлыг 2018-2020 онд 258-1,978 тэрбум төгрөгийн зээлээр санхүүжүүлсэн байна. Тэгвэл гадаад тусламжийн 53.3 хувийг Азийн хөгжлийн банк, 18.9 хувийг БНХАУ, 9.8 хувийг Япон улсаас авч, тусламжийн 48.9 хувийг эрүүл мэнд, 21.4 хувийг боловсролын салбарт тус тус зарцуулжээ. (Диаграмм 2)

¹ Төрийн аудитын байгууллага, Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүн, Улаанбаатар, 2022 он, <https://www.audit.mn>

² Төрийн аудитын байгууллага, Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүн, Улаанбаатар, 2022 он, <https://www.audit.mn>

Диаграмм 2. Авсан гадаадын тусламж ба түүний ашиглалт



Эх сурвалж: Төрийн аудитын байгууллага (2022 он)³

Орчин үеийн Монгол Улсын эдийн засаг Хятадаас экспортын хувьд 80-90 хувийн хамааралтай. Үүний хамт БНХАУ-аас авсан зээл, өрийн бичгийн хэмжээ Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдлийн 18.9 хувийг эзэлж байна.⁴ Энэ нь бид Хятадын гадаад тусламжийн бодлогыг тодорхой хэмжээнд ажиглах, Хятад улсаас бусад улсуудад үзүүлж буй гадаад тусламжийн бодлоготой уялдуулан судлах хэрэгцээ шаардлага байгааг харуулна.

Хятадын гадаад тусламжийн бодлогын талаар В.Б.Кашин нарын судалгаанд Хятадын гадаад тусламжийн зарчим, суурь ойлголтуудыг харьцангуй ул үндэстэй тодорхойлжээ⁵. Монгол, Хятадын харилцааны түүхэнд холбогдох судалгааны бүтээл, баримтын эмхэтгэл, катологиуд болон зарим судалгааны өгүүлэлд Хятад улсаас Монголд үзүүлж ирсэн гадаад тусламжийн хэмжээ, гүйцэтгэл, үр дүнг тоймлосон бий⁶. Д.Шүрхүү Хятадын зөөлөн хүчний бодлогын нэг чухал чиглэл нь гадаад тусламжийн бодлого байдгийг онцлоод, Африкийн буурай хөгжилтэй улсууд болон Зүүн Өмнөд Азийн улсуудад Хятадын гадаад тусламжийн бодлого

³ Мөн тэнд.

⁴ С.Баттулга нар, Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдал, Судалгааны тайлан, Улаанбаатар, 2023.

⁵ Кашин В. Б., Королев А. С., Пятачкова А. С. Китайская политика помощи зарубежным странам: основные принципы и направления // Китай в мировой и региональной политике. История и современность. 2017. №22. URL: <https://cyberleninka.ru/article/n/kitayskaya-politika-pomoschi-zarubezhnym-stranam-osnovnye-printipy-i-napravleniya> (дата обращения: 08.04.2024).

⁶ Найрамдал, хамтын ажиллагааны нэгэн жаран, Бээжин, 2009; Монгол-Хятадын харилцаа жарнаас жаранд. Улаанбаатар. 2009; Жоу Эньлай ба Монгол орон, Улаанбаатар: Архивын Ерөнхий Газар, 2014; Болормаа, Г. "Монгол-Хятадын иж бүрэн стратегийн түншлэл дэх зээл, тусламжийн асуудал". Монгол, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны явц, сорилт, боломж. Улаанбаатар, 2015; Эдийн засаг, хөгжлийн яам, БНХАУ-аас Монгол Улсад үзүүлж буй зээл, тусламж, Улаанбаатар, 2022, танилцуулга. Холбоос: https://www.mongolbank.mn/file/a0e0b19a1d9077d161459638a368078f/files/20220621_05.pdf. Хамгийн сүүлд: 2024.02.03; Батхүү.И, "Монгол Улс, БНХАУ-ын хөгжлийн хамтын ажиллагааны оргил үе тохиож байна", Мөнгө санхүү, баялаг этгүүл, Улаанбаатар., 2022 он.

нэмэгдэж буйг онцолжээ⁷. Тэгвэл сэтгүүлч Ц.Оюунчимэг Хятадаас авч буй гадаад тусламж нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй гэх болгоомжлолыг илэрхийлж байна.⁸ Эдгээрээс гадна Монгол Улс Хятадын өрийн хавханд орох эрсдэлийг сануулсан нийтлэлүүд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдэд үе үе хэвлэгддэг.

Хятадаас Монголд үзүүлж ирсэн гадаад тусламжийн нийт хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл нэлээн тодорхой юм. Гэвч Хятадын нийт гадаад тусламжийн бодлогыг Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан авч үзсэн судалгаа харьцангуй цөөвтөр байна. Энэ өгүүллээр Хятадын нийт гадаад тусламжийг үндсэн нөхцөл, зарчмуудыг тоймлон үзэж, тэдгээрийг Монгол Улсын нөхцөл байдал дээр тайлбарлахыг зорив.

Хятадын гадаад тусламжийн түүхийн тойм ба үечлэл. Гадаад тусламжийг дараах үе шатуудад хувааж болно.

- **1950-1978 он.** Хятад улсын гадаад тусламж нь анх ганцаардлаас салж, олон улсын хамтын нийгэмлэгт нэгдэхийн зэрэгцээ хөгжиж буй орнуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжих зорилготой байв.
- **1978-2010 он.** Өөрчлөлт, нээлттэй хаалганы бодлогын үеэс эхлэн Хятад улсын гадаад тусламжийг дотоодын эдийн засгийн хөгжлийн хэрэгцээг хангахын тулд байнга тохируулж, гадаад тусламжийн сангийн цар хүрээ хумигдсан ч үйлдвэржилттэй холбоотойгоор 1990-ээд оноос эхлэн Хятад улс гадаад худалдаа, хөрөнгө оруулалтаа дэмжихэд гадаад тусламжийг уялдуулах болов.
- **2010 оноос хойш өнөөг хүртэл.** Хятад улс иж бүрэн хүч чадал, олон улсын статусаа дээшлүүлэхээр, гадаад тусламжийн бодлогыг улам идэвхтэй хэрэгжүүлж буй үе хэмээн ангилдаг.

1950-1978 он. 1949 онд Хятадын Коммунист Нам (ХКН)-ын удирдлага дор Бүгд Найрамдах Хятад Ард Улс байгуулагдсаны дараа Хятад улс ЗХУ-ын бүх талын хяналтыг даван туулах, социализм байгуулах өөрийн онцлогтой арга замыг бий болгох, түүндээ социалист бусад улс орнуудын дэмжлэгийг авахын тулд явуулсан үйл ажиллагаануудын нэг нь Хятадаас социалист орнуудад үзүүлсэн гадаад тусламж байв. Үүнийг бүхэлд нь нөлөөгөө тэлэх, Зөвлөлттэй далдуур өрсөлдөх үйл ажиллагаа гэж үзэж болно.

БНХАУ-ын анхны гадаад тусламжийг хүлээн авсан улс бол Солонгос хойгийн дайны үеийн БНАСАУ байв. 1950 оноос 1960 оны 6-р сар хүртэл Хятадаас социалист ба социалист бус улсуудад нийт 6.4 тэрбум рублийн тусламж, үүнээс социалист орнуудад 5.6 тэрбум рублийн тусламж олгожээ. Ялангуяа 1956 онд ЗХУКН-ын XX их хурлаар нэг хүнийг тахин шүтэх явдлыг шүүмжилсний дараа

⁷ Д. Шүрхүү. 2007. “БНХАУ-ын софт хүч чадлын өсөлт, түүний олон улсын үр нөлөө”. *Journal of International Studies* 4 (4):29-36. <https://doi.org/10.5564/jis.v4i4.2093>.

⁸ Оюунчимэг, Ц. Зээл тусламжийн бодлого хаашаа чиглэж байна вэ, Ерөнхий сайд аа? *Zindaa.mn*, 2017. Холбоос: <https://news.zindaa.mn/23b4> . Хамгийн сүүлд 2024.02.03.

Зөвлөлт-Хятадын хооронд далд зөрөлдөөн эрчимжиж, жижиг социалист орнуудад зээл, тусламж үзүүлэх явдал нэмэгдэв. Ийнхүү Хятад улс социалист орнуудын дотор өөрийн нөлөө, байр суурийг өргөх гол арга хэрэгсэл нь эдийн засгийн зээл, тусламж болон хувирсан бөгөөд Монгол улс ч үүний нэгэн оролцогч болон хувирав. Иймээс Хятад улсын гадаад тусламж нь анх ганцаардлаас салж, олон улсын хамтын нийгэмлэгт нэгдэхийн зэрэгцээ хөгжиж буй орнуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжих зорилготой байв. Тухайлбал, 1956 онд Суэцийн хямралын үеэр Египетэд 20 сая швейцарь франк хандивласан үеэс Хятадын гадаад тусламжийн үндсэн зарчмууд тавигдсан гэж хэлж болно. 1970-аад онд Хятадын гадаад тусламжид зүүний үзэл суртлын зарим чиг хандлага нөлөөлсөн бөгөөд тус улсын тусламжийн хэмжээ өөрийн улсын хүчин чадлаас хэтэрч, зарим хүндрэлүүд ч гарч байв. Учир нь Хятад улс гадаад тусламжийн хөтөлбөрөө хэрэгжүүлж эхлэхэд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ Хятадаас өндөр байсан орнуудад хүртэл тусламж үзүүлж байсан ганц ядуу улс байсан⁹. 1974 онд (Хятадын удирдагч Мао Зэдуны засаглалын төгсгөл дөхөж) тусламжийн хэмжээ нь үндэсний нийт бүтээгдэхүүний хоёр хувьд хүрч, өндөр хэмжээнд хүрсэн. Үүний дараа гадаад тусламжийн хэмжээ нь Хятадын хөгжил цэцэглэлтийн өсөлтийг дагаад нэмэгдсэн ч түүний эзлэх хувь мэдэгдэхүйц буурч, тусламж үзүүлэх сэдэл нь илүү прагматик болж, агуу үзэл суртлыг сурталчлахад бага зэрэг чиглэгддэг болов.

1978-2010 он. Өөрчлөлт шинэчлэлт, нээлттэй хаалганы бодлогын дараа Хятад улсын гадаад тусламжийг дотоодын эдийн засгийн хөгжлийн хэрэгцээг хангахын тулд байнга тохируулж, гадаадын тусламжийн сангийн цар хүрээ ч хумигдсан¹⁰. Энэ үед Хятадын гадаад тусламж дотоодын эдийн засгийн хөгжлийг дэмжиж, үйлчлэхийн тулд гадаад орчныг тогтвортой байлгах хандлагатай болов. Тиймээс хөрөнгийн хязгаарлагдмал тохиолдолд тусламжийн төслүүдийн үр ашигт илүү анхаарал хандуулдаг болсон.

2010 оноос хойш өнөөг хүртэл. XXI зуунд, Хятад улсын иж бүрэн хүч чадал, олон улсын статусаа дээшлүүлэхийн тулд гадаад тусламжийн бодлогыг улам идэвхтэй хэрэгжүүлж эхэлсэн. Тухайлбал, Хятад, Африкийн хамтын ажиллагааны форум, Өмнөд өмнөдийн хамтын ажиллагаа, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тусламжтайгаар тусламжийн арга хэмжээгээ илүү өргөн болгосон жишээтэй. Хятад-Африкийн хамтын ажиллагааны форумын дээд хэмжээний уулзалтын үеэр Хятад улс Африкт туслах “Шинэ, хуучин найман” хэмээх тогтолцоотой арга хэмжээг зарласан нь чухал агуулгатай байв. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулган дээр Хятад улс мөн гадаадын тусламжийн хэд хэдэн арга хэмжээ авахаа мөн зарласан байна.

XXI зууны эхэн үеэс Хятадын гадаадын зээл, тусламжийн бодлого хандлага,

⁹ Н.Алтантөгс., “Хятадаас 1956-1960 онд Монголд зориулж олгосон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн үр дүнг шинжлэх нь”, www.esan.mn/p/research/investmen

¹⁰ Кашин В. Б., Королев А. С., Пятачкова А. С. Китайская политика помощи зарубежным странам: основные принципы и направления // Китай в мировой и региональной политике. История и современность. 2017. №22. URL: <https://cyberleninka.ru/article/n/kitayskaya-politika-pomoschi-zarubezhnym-stranam-osnovnye-principy-i-napravleniya> (дата обращения: 08.04.2024).

цар хүрээний хувьд системтэй, идэвхтэй болсон гэж хэлж болно. Ялангуяа Хятадын Коммунист намын XVIII их хурлаас хойш Хятадын гадаад тусламж хөгжлийн шинэ үе шатанд орох болов. БНХАУ-ын дарга Ши Жиньпин “Бүс ба Зам” санаачилга, “Хүн төрөлхтний хамтын ирээдүйтэй хамтын нийгэмлэгийг хамтдаа байгуулах” алсын харааг дэвшүүлснээр Хятад улсын гадаад тусламж нь үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны уялдаа холбоог 2017 оны эхнээс авч үзэж, түүнчлэн үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай болсон. Иймд 2018 онд Хятадын Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентлаг (CIDCA) нь Хятадын гадаад тусламжийн үйл явцыг оновчтой болгох зорилгоор байгуулагдсан бөгөөд үүнд Худалдаа, Гадаад хэргийн яам, Төрийн зөвлөл мөн оролцож эхлэв.

Өнөөгийн Хятадын гадаад тусламжийн ерөнхий тойм

Шинэ Хятадын гадаадын зээл, тусламжийг төрийн (албан ёсны) болон хувийн хэвшлийн хөгжлийн тусламж, Хятадаас гаралтай хүмүүсийн хүмүүнлэгийн тусламж хэмээн гурав ангилж үздэг. Хятадын гадаад тусламж нь өргөн цар хүрээтэй, олон талт байна. Үүнд хөгжиж буй орнууд, ялангуяа Африк, Азийн орнуудад олгох буцалтгүй тусламж, хүүгүй зээл, хөнгөлөлттэй зээлүүд багтдаг.

Хятадын албан ёсны тусламж нь үндэсний томоохон тусламжийн эх үүсвэрээс ялгаатай нь ЭЗХАХБ-ын Хөгжлийн албан ёсны тусламж (ODA) протоколын дагуу зохицуулагддаггүй, мөн хэмжигддэггүй. ЭЗХАХБ-ын тооцоолсноор 2020 он гэхэд Хятадын хөгжлийн албан ёсны гадаад тусламж 4.8 тэрбум ам.долларт хүрсэн байна. (График 2)

График 2. БНХАУ-аас гадаадад үзүүлж буй тусламжийн хуваарилалт



Эх сурвалж: <https://www.chinca.org/CICA/info/18042717515511>

Хятадын хөгжлийн албан ёсны гадаад тусламжийн бараг тэн хагас нь буурай хөгжилтэй улсуудыг чиглэж, түүний дотор хөнгөлөлттэй зээл ба буцалтгүй тусламж нь хэмжээгээр ойролцоо жин эзэлж байна. Үүний ихэнх нь Африк болон Ази тивийн улсуудад зориулагджээ.

Хятад улсын гадаад тусламжийн сангаас (Диаграмм 3) харахад хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн харьцаа бараг зөрүүгүй байна. Харин хугацаагүй зээлийг маш бага олгодог нь харагдаж байна.

Диаграмм 3. БНХАУ-ын гадаад тусламжийн сангийн хуваарилалт




Эх сурвалж: Three Key Shifts on Development Cooperation in China's 2021 White Paper

График 3. Хятад улсын гадаад зээл олголт он дарааллаар



Эх сурвалж: Three Key Shifts on Development Cooperation in China's 2021 White Paper


График 4. 2013-2022 онд Хятад улсаас олгосон гадаад тусламж бүс нутгаар



Эх сурвалж: Three Key Shifts on Development Cooperation in China's 2021 White Paper¹¹

¹¹ Three Key Shifts on Development Cooperation in China's 2021 White Paper, Center For Global Development, Холбоос: <https://www.cgdev.org/blog/three-key-shifts-development-cooperation-chinas-2021-white-paper>

График 5. Хятад улсын гадаад тусламжийн 2010-2018 оны зардлын хэмжээ



Эх сурвалж: *Three Key Shifts on Development Cooperation in China's 2021 White Paper*¹²

Гадаад тусламжийн зардал нь 2010-2012 оны үеэс 2013-2018 он хүртэл 45 гаруй хувиар (жил бүр ойролцоогоор 4.8 тэрбум доллароос 7.0 тэрбум доллар хүртэл) өссөнийг харуулж байна.

Хятадын гадаад тусламж нь ихэвчлэн авто зам, төмөр зам, боомт зэрэг дэд бүтцийн төслүүдэд анхаарлаа хандуулж, эмнэлгийн тусламж үзүүлэх, хөдөө аж ахуйг хөгжүүлэх, боловсролын хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зэрэгт төвлөрдөг. Тухайлбал,

Эдийн засгийн дэд бүтэц. Өнөөг хүртэл Хятад улс хөгжиж буй орнуудад эдийн засгийн дэд бүтцийн 500 төслийг хэрэгжүүлэхэд тусалсан байна. Тухайлбал, Хойд Солонгос: Дандонг дахь Ялу голын шинэ гүүр барих төслийн нийт өртөг нь 2.2 тэрбум юань, Түмэн голын гүүрийг барихад ойролцоогоор 137 сая юань, Мьянмар Гунонг гүүр, Хятад-Мьянмарын найрамдлын гүүр, Танзани-Замбийн төмөр зам, Транс Монголын төмөр зам, Этиопын сэргэн мандалтын далан, Мерови далан, Судан Хятад Балбын найрамдлын гүүр, Ресуо гүүр, Тажикстан дахь Шар туннель зэрэг буцалтгүй тусламж үзүүлсэн юм. Мөн Пакистан Исламабад олон улсын нисэх онгоцны буудал, Каракорамын хурдны зам, Гвадар боомт, Йемений Сана хотоос Ходейда хүртэлх зам, Сомалийн Белетвин-Блау зам, Малйт дахь хуурай усан онгоцны зогсоол, Камеруны Лагду усан цахилгаан станц, Мавритани дахь Найрамдлын боомт, Ботсван дахь төмөр замын сэргээн босголт, Бангладеш, Лаос дахь 6 гүүр, Кунмин-Манганг хурдны замын хэсэг, Мьянмар дахь Их Меконг голын дэд бүсийн мэдээллийн хурдны зам, Камбожийн 7-р хурдны зам, Этиопийн Гетра уулзвар зэрэгт тусламжийн үзүүлсэн байна. Мөн Хятад улс хөгжиж буй орнуудад олон төрлийн 700 гаруй нийтийн барилга байгууламж барихад тусалсан байна.

2011 оны эцэс гэхэд БНХАУ хүлээн авагч орнуудад үйлдвэрлэл, амьдралтай

¹² *Three Key Shifts on Development Cooperation in China's 2021 White Paper*, Center For Global Development, Холбоо: <https://www.cgdev.org/blog/three-key-shifts-development-cooperation-chinas-2021-white-paper>

холбоотой 2200 гаруй төсөл хэрэгжүүлэхэд тусалж, орон нутагт техникийн үйлчилгээ үзүүлэх, зааварчилгаа өгөх техникийн ажилтнуудыг илгээсэн байна. Мөн хүлээн авагч орнуудад их хэмжээний материаллаг болон мөнгөн тусламж үзүүлсэн.

Боловсрол. 2020 он гэхэд Хятад улс хөгжиж буй орнуудад 200 гаруй сургууль барихад тусалсан. Хөгжиж буй 119 орны нийт 70,627 гадаад оюутныг Хятадад төрөл бүрийн мэргэжлээр суралцахаар санхүүжүүлснээс 2009 онд 11,185 гадаад оюутанд тэтгэлэг олгосон байна. Нийт 10,000 шахам гадаад тусламжийн багшийг илгээсэн. Хүлээн авагч орнуудад нийт 10,000 гаруй захирал, багш нар сургалтад хамрагдсан байна.

Эрүүл мэнд. 2009 оны эцэс гэхэд Хятад улс хөгжиж буй орнуудад 100 гаруй эмнэлэг, эмнэлгийн үйлчилгээний төв барихад тусалж, их хэмжээний эмнэлгийн тоног төхөөрөмж, эм тариа нийлүүлсэн байна. 30 гаруй эмнэлэг баригдаж байна. Йемений Таз эмнэлэг, Хятад-Африкийн найрамдлын эмнэлэг, Гвиней-Бисаугийн Сонго эмнэлэг, Зимбабвегийн Чиной эмнэлэг, Чад дахь Либерти эмнэлэг, Лаосын Луан Прабанг эмнэлгийг Хятадын тусламжаар барьжээ. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд Хятад улс Африкийн орнуудад хумхаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх 30 төв байгуулж, 190 сая юанийн үнэ бүхий артемизиний гаралтай хумхаа өвчний эсрэг эм нийлүүлсэн байна.

Гадаадын тусламжийн эмнэлгийн баг. 1963 онд Хятад улс анхны эмнэлгийн багаа Алжир руу илгээжээ. 1963 оноос 2009 оны эцэс хүртэл Хятад улс хөгжиж буй 69 оронд гадаадын тусламж үзүүлэх эмнэлгийн баг илгээж, 21 мянга орчим эмнэлгийн ажилтан илгээж, тусламж хүлээн авагч улс орнуудад 260 сая өвчтөнийг Хятадын эмч нар эмчилсэн.


Гадаадын тусламжийн сайн дурынхан. 2005 оноос хойш БНХАУ сайн дурын залуусаа гадаадад илгээж эхэлсэн. Одоогийн байдлаар 470 гаруй гадаадын тусламжийн сайн дурынхныг дэлхийн 19 оронд илгээж, Хятад хэл заах, Хятадын уламжлалт анагаах ухааны эмчилгээ, хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, технологи, биеийн тамир, компьютерын сургалт, олон улсын аврах ажилд сайн дурын үйлчилгээ үзүүлээд байна.

Томоохон гамшгийн тусламж. Байгалийн томоохон гамшигт нэрвэгдсэн улс орнуудад цаг алдалгүй хүмүүнлэгийн тусламж үзүүлж байна. БНХАУ-аас гадаадын улс орнуудад 200 шахам хүмүүнлэгийн тусламж үзүүлжээ. 2004 оны 12-р сард Энэтхэгийн далайд цунами болсны дараа Хятад улс гадаадын тусламжийн түүхэн дэх хамгийн том яаралтай аврах ажиллагааг эхлүүлж, гамшигт нэрвэгдсэн орнуудад нийт 700 сая гаруй юанийн тусламж үзүүлжээ. 2011 оны 12-р сарын 22-ны өдөр Филиппиний өмнөд хэсгийн олон мужид «Скайхок» хэмээх халуун орны шуурга хүчтэй үерийн гамшигт нэрвэгдэв. БНХАУ-аас Филиппинд гамшгийн үед тусламж үзүүлэхэд нэг сая ам.долларын тусламж үзүүлэв. Үүнээс гадна Филиппинд суугаа БНХАУ-ын Элчин сайдын яамнаас 10 мянган ам.долларын тусламж үзүүлжээ.

Нэг бүс, нэг зам. БНХАУ-ын Засгийн газар Азийн эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор 2014 онд Торгоны замын сан байгуулахад 40 тэрбум ам.долларын

хөрөнгө оруулалт хийсэн. Тус сан нь “Бүс ба зам” дагуух улс орнуудын дэд бүтэц, бүтээн байгуулалт, аж үйлдвэрийн хамтын ажиллагаа болон бусад төслүүдийг санхүүжүүлэх юм. 2017 онд Ши Жиньпин тус сангийн хөрөнгийг дахин 100 тэрбум юаниар нэмэгдүүлэхээ мэдэгдсэн. Гэсэн хэдий ч гадны эрдэмтэн, судлаачид Хятадын тусламжийн арга барилыг ил тод бус, хүлээн авагч орнуудын өрийн тогтвортой байдалд санаа зовдог хэмээн шүүмжилдгийг тэмдэглэх нь зүйтэй. (График 6)

График 6. БНХАУ-д хамгийн их өртэй орнууд дахь бусад зээлдэгч нарын харьцаа 2018 оны дөрөвдүгээр улирлын байдлаар



Эх сурвалж: Varrall, Merriden. “Chinese Worldviews and China’s Foreign Policy.”¹³

Өрийг чөлөөлөх. Хятадын Засгийн газар 2000 онд болсон Хятад, Африкийн хамтын ажиллагааны форумын Сайд нарын анхдугаар бага хурал, 2005 оны НҮБ-ын хөгжлийн санхүүжилтийн дээд хэмжээний бага хурал, 2006 оны Хятад, Африкийн хамтын ажиллагааны форумын Бээжингийн дээд хэмжээний уулзалт, 2008 оны НҮБ-д оролцсон. Мянганы хөгжлийн зорилтын дээд хэмжээний бага хурал, 2009 оны Хятад-Африкийн хамтын ажиллагааны чуулга уулзалт, Мянганы хөгжлийн зорилтын асуудлаарх Сайд нарын IV бага хурал болон 2010 оны НҮБ-ын дээд хэмжээний уулзалтын үеэр их хэмжээний өр зээл байгааг зургаан удаа зарласан. Өртэй ядуу орнууд болон Хятадтай дипломат харилцаатай буурай хөгжилтэй орнуудыг Хятадад олгох хүүгүй зээлийн хугацаанаас чөлөөлнө. 2009 оны эцэс гэхэд Хятад улс Африк, Ази, Латин Америк, Карибын тэнгис, Далайн 50 улстай өр тэглэх протоколд гарын үсэг зурж, 25 тэрбум 580 сая юанийн хугацаа дууссан 380 өрийг тэглэсэн байна. Хөгжингүй орнуудын Хятадад төлөх өрийг бууруулах, бууруулах. 2011 оны эцэс гэхэд БНХАУ их өртэй ядуу буурай болон буурай хөгжилтэй 50 орны нийт 391 өрийг өршөөжээ.

Гадаад тусламжийн дөрвөн нөхцөл

Өнөөгийн Хятадын гадаад тусламж нь олон улсын хөгжлийн хамтын

¹³ Varrall, Merriden. “Chinese Worldviews and China’s Foreign Policy”, Lowy Institute for International Policy, 2015. <http://www.jstor.org/stable/resrep10139>.

ажиллагааны ерөнхий шинж чанартай төдийгүй онол практикийн шинж чанартай юм.

“БНХАУ-ын гадаад тусламж” хэмээх Анхны цагаан номд: «БНХАУ-ын гадаад тусламж нь эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмыг баримталж, бодит үр дүнд анхаарлаа хандуулж, цаг үетэй хөл нийлүүлэн алхаж, улс төрийн ямар ч нөхцөл автахгүй, өөрийн онцлогтой загварыг баримтална” хэмээн бичжээ.¹⁴

Карнеги-Цинхуагийн Сун Шюэфэнгийн зохион байгуулсан дугуй ширээний ярилцлага дээр Финландын Олон улсын харилцааны хүрээлэнгийн ажилтан Матти Ножонен, Микаэл Матлин нар Хятадын гадаад тусламжийн дөрвөн нөхцөлийг дараах байдлаар тоймлон үзэж байна. Үүнд:

Улс төрийн нөхцөл: Тусламж, зээл авахын тулд тусламж хүлээн авагч улс нэг Хятадын зарчмыг баримтлах ёстой бөгөөд эх газрын Хятад, Тайваньтай албан ёсны харилцаатай байж болохгүй. 2006 онд Вьетнам Тайванийн албаны хүмүүсийг АПЕК-ийн уулзалтад урьсан бөгөөд Хятад хариу арга хэмжээ авч Вьетнамын санхүүжилтийг зогсоосон юм.

Шууд бус нөхцөл: Хятадын тусламжийг хүлээн авагч аль ч улс Хятадын хөдөлмөр, нөөцийг ашиглахыг зөвшөөрч, Хятадын аж ахуйн нэгжүүдийн тогтоосон дүрэм журмыг дагаж мөрдөх ёстой. Дотоодын ажиллах хүч, хөрөнгийн багахан хувийг тодорхой төслүүдэд ашиглах боломжтой байдаг ч Хятадын компаниуд гол төслүүдийн ажлыг бүгдийг нь биш юмаа гэхэд ихээхэн хэсгийг хариуцдаг. Эдгээр дүрмийн дагуу Хятадын тусламж нь үнэн хэрэгтээ өөрийн улсын ашиг сонирхолтой холбоотой тусламж юм.

Харилцан хамаарлын нөхцөл: Хятадын тусламжийг хүлээн авч байсан олон үндэстэн эдийн засгийн стратегийн салбарт Хятадаас ихээхэн хамааралтай болсон тухай зарим нотолгоо бий. Энэ нь стратегийн салбаруудад Хятад давамгайлсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлж байгаатай холбоотойгоор цаг хугацааны явцад бий болдог бүтцийн нөлөө юм. Тиймээс Хятадын нөөцийг ашиглахыг шаардах нь институцичлагдсан хараат байдалд хүргэдэг.

Салбарын хөшүүрэгт нөхцөл: Хятадын банкуудын санхүүжилт нь Хятад эсвэл Хятадын аж ахуйн нэгжүүдэд тусламж, зээлийн хэлэлцээрээс гадуур нэмэлт шаардлагыг хүлээн авагч улсдаа хөшүүрэг болгох боломжийг олгодог. Жишээлбэл, 2009 онд Хятад Индонези Хятадын нисэх онгоц худалдаж авахаас татгалзсаны улмаас Индонезид эрчим хүчний хөгжлийн санхүүжилтээ зогсоосон.¹⁵

Хятадаас гадаад худалдааны өндөр хамааралтай Монголын хувьд эдгээр дөрвөн нөхцөл бодит байдал дээр үнэхээр оршдог эсэх, нөлөөллийн түвшин нь ямар байх талаар зарим таамаглал дэвшүүлэхийн тулд Хятадаас Монголд үзүүлж буй гадаад тусламжийн одоогийн нөхцөл байдлыг тоймлон үзье.

Хятадын гадаад тусламж ба Монгол

Монгол Улс хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагаас 2019 онд 1,242.3

¹⁴ 《中国的对外援助》白皮书（中文），Холбоо: http://www.cidca.gov.cn/2018-08/06/c_129925064_2.htm

¹⁵ Conditionality in China's Aid Model, Холбоо: <https://carnegieendowment.org/2012/01/10/conditionality-in-china-s-aid-model-event-4024>

тэрбум төгрөгийн зээл, тусламж ашиглахаас 525.7 тэрбум төгрөг буюу 42.3 хувийг Азийн хөгжлийн банк, 254.9 тэрбум төгрөг буюу 20.5 хувийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зээл, тусламж эзэлж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн 2019 оны ашиглалт

Хөгжлийн түнш	(тэрбум.төгрөг)		
	Гадаад зээлийн ашиглалт	Гадаад тусламжийн ашиглалт	НИЙТ ДҮН
Азийн хөгжлийн банк	493.1	32.6	525.7
Хятад	205.7	49.2	254.9
Япон	125.8	18.9	144.7
Дэлхийн банк	109.0	10.6	119.6
Өмнөд Солонгос	43.7	0.5	44.2
Энэтхэг	46.7	-	46.7
Польш	16.0	-	16.0
Австри	14.3	-	14.3
Кувейт	-	18.7	18.7
Герман	22.3	12.0	34.3
Бельги	6.4	-	6.4
ХАХОУС	5.4	-	5.4
Беларус	3.5	-	3.5
Унгар	1.0	-	1.0
ЕСБХБ	2.0	0.5	2.5
НУБ	-	1.9	1.9
Франц	1.5	-	1.5
Швейцарийн хөгжлийн агентлаг	-	0.7	0.7
НИЙТ ДҮН	1,096.3	146.0	1,242.3

Эх сурвалж: <https://mof.gov.mn/files/uploads/Tusuv2019-ver2.pdf>

Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөрт “Хятадын тал Монголын талд бололцооныхоо хэрээр үргэлжлүүлэн тусламж үзүүлэхийн зэрэгцээ Монголын төрөл бүрийн салбарын боловсон хүчнийг сургах ажлын цар хүрээг өргөжүүлнэ. Хоёр тал энэ салбарын хамтын ажиллагаагаа улам бэхжүүлж, уялдаа холбоо, зохицуулалтаа эрчимжүүлэн, зээл тусламжийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлнэ”¹⁶ хэмээн гадаад тусламжийн харилцааг хөгжүүлэхээр заажээ.

Монгол, Хятад хоёр улсын хөгжлийн хамтын ажиллагаа нь буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, техникийн туслалцааны хэлбэрээр явагддаг.

Монгол-Хятадын зээл, тусламжийн харилцааны түүх эн тэргүүн Хүйтэн дайны эхэн үед холбогдох юм. Хүйтэн дайны үед Хятадаас жижиг социалист орнуудад тусламж үзүүлэх явдал нь дэлхийн социалист блок ба Ази, Африкийн хөгжиж байгаа улсуудын дунд улс төр, эдийн засгийн байр сууриа бэхжүүлэх зорилго бүхий Хятадын гадаад бодлогын нэгэн чухал хэсэг байв. БНХАУ байгуулагдсаны дараа

¹⁶ “Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр”. 2013. *Journal of International Studies*, December, 96-110. <https://www.mongoliajol.info/index.php/JIS/article/view/1672>.

гадаад тусламжийн идэвхтэй бодлого явуулж, үүний дотор 1956-1960 онд Монгол улсад нийт 460 сая рублийн буцалтгүй тусламж ба хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн нь Монгол-Хятадын харилцааны түүхэнд урьд өмнө байгаагүй шинэ үйл явдал болов.

Орос, Хятадын хооронд оршдог Монгол улсад өнөө үед хамгийн их буцалтгүй тусламж үзүүлдэг, хамгийн их гадаадын хөрөнгө оруулагч улс нь БНХАУ болсон бөгөөд түүний эдийн засгийн нөлөө дэлхий дахинд, түүний дотор умард хөрш Монгол улсад зогсолтгүй нэмэгдэж байв. Ялангуяа 1990 оноос хойш тус хоёр улсын харилцаа эдийн засгийн талаар хурдацтай хөгжиж, үүний дотор Хятадаас Монголд үзүүлэх буцалтгүй тусламж ба хөнгөлөлттэй зээл их ирэв. Энэхүү өсөн нэмэгдэж буй Хятадын зээл, тусламжийг чухал шаардлагатай салбарт зориулах, үр дүнг бүрэн гүйцэт гаргах, тусламжийн үр дүнгийн тухай хоёр талын сонирхлыг адил тэнцүү хангахын тулд Хятадаас Монголд тусалж байсан урьд өмнөх туршлагыг харгалзан үзэх нь зүйн хэрэг.

2005-2017 онд Хятадаас Монголд нийт 1.8 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл, 3.3 тэрбум юанийн буцалтгүй тусламж олгохоор амласан. Дээрх эх үүсвэрээс 2022 оны байдлаар хөнгөлөлттэй зээлээр “Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төсөл”, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл”, “Замын цагдаагийн ойролцоох гүүрэн гарц барих төсөл” зэрэг нийт 931.7 сая долларын 16 төслийг хэрэгжүүлж дуусгасан¹⁷ бол 326.6 сая долларын гурван төсөл хэрэгжих шатандаа, харин 493 сая долларын долоон төсөл судалгааны шатандаа явж байна. Буцалтгүй тусламжийн хувьд “Буянт-Ухаа спортын ордон барих төсөл”, “7 сургууль болон 1 цэцэрлэг барих төсөл”, “Ой хээрийн түймэртэй тэмцэх техник, багаж хэрэгслийг шинэчлэн сайжруулах төсөл” зэрэг нийт 93.6 сая юанийн дөрвөн төсөл хэрэгжүүлж дууссан бол 696.4 сая юанийн хоёр төсөл хэрэгжих шатандаа, 936.6 сая юанийн найман төсөл судалгааны шатандаа байна.

Монгол Улс Хятад улсаас авсан хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хөдөө аж ахуйн салбарын дөрвөн төсөл, боловсролын салбарын хоёр төсөл, дэд бүтцийн 11 төсөл, эрүүл мэндийн нэг төсөл, эрчим хүчний салбарын гурван төслийг тус тус хэрэгжүүлэхээр хоёр тал тохиролцсоноос зээлийнхээ тэн хагасаас илүүг зарцуулж дуусгасан боловч харин буцалтгүй тусламжийн хувьд ердөө 2.8 хувийг зарцуулжээ.

*Хүснэгт 2. Хятад улсаас авсан хөнгөлөлттэй зээл,
буцалтгүй тусламжийн хэрэгжилт*

	№	Ерөнхий хэлэлцээрийн эх үүсвэр	Дууссан		Хэрэгжиж байгаа		Судалгааны шатанд		НИЙТ	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗЭЭЛ	1	300.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл /2005/	5	293.3	-	-	-	-	5	293.3
	2	500.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл /2011/	8	431.1	1	63.9	-	-	9	495.0

¹⁷ Сангийн яамны сайт. Холбоос: <https://mof.gov.mn/article/entry/mnchinacooperation>

	3	1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл /2015/	3 207.3	1 262.7	7 493	11 963.0
		Нийт	16 931.7	3 326.6	7 493	25 1,751.3
ТУСЛАМЖ	1	300.0 сая юаны буцалтгүй тусламж /2014/	- -	1 250.2	-	1 250.2
	2	1.0 тэрбум юаны буцалтгүй тусламж /2014 /	4 93.6	2 696.4	2 146.6	8 936.6
	3	2.0 тэрбум юаны буцалтгүй тусламж /2017/			4 2,000.0	4 2,000.0
		Нийт	4 93.6	3 946.6	6 2,146.6	13 3,186.8

Эх сурвалж:

2020 онд БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И өнгөрсөн долоо хоногт манай улсад айлчилсан. Айлчлалын үеэр 700 сая юанийн буцалтгүй тусламж олгохоо мэдэгдэж хоёр тал “Солилцох захидал”-ыг байгуулсан билээ. БНХАУ нь 2017 онд хоёр тэрбум юань, 2018 онд 700 сая юань, 2019 онд 600 сая юанийн буцалтгүй тусламжийг тус, тус олгохоо мэдэгдсэн юм. Эдгээрээс гадна шинэ цэвэрлэх байгууламж /300 сая доллар/, Налайхын зам /36 сая доллар/, Дарханы зам /БНХАУ-ын 101.5 сая үлдсэнг нь Европын сэргээн босголтын банкнаас/ Хөшигтийн хөндийн хурдны зам /140.3/, Яармагийн гүүр /30 сая доллар/, Хоум плазагийн гүүр /42.38 сая доллар/ гэх мэт томоохон байгууламжуудыг БНХАУ-ын зээл, санхүүжилтээр барьсан байна.

Хятадын гадаад тусламжийн хүрээнд хэрэгжиж буй зарим төслийг жагсаавал:

1. Хилийн боомтын дэд бүтэц төсөл Замын-Үүд боомт, Гашуунсухайт боомт /349.0 сая юань/ 2019 он – 2023 он/
2. Монгол Улсын Замын-Үүд боомт, Гашуунсухайт боомтын дэд бүтцийг шинэчилж, бүтээн байгуулалт хийн гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ.
3. Эрдэнэбүрэнгийн 90мвт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барих төсөл 271.5 сая ам.доллар /2022 он – 2027 он/
4. Баруун бүсийн эрчим хүчний хэрэгцээг найдвартай эх үүсвэрээр хангаж, дотооддоо эрчим хүч үйлдвэрлэнэ.
5. Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл /22.1 сая ам.доллар /2022 он – 2027 он/
6. Үндэсний радио долгионы хяналт, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын систем.

Хоёр улсын хоорондын худалдааны эргэлт 2019 оны эцсийн байдлаар 8.8 тэрбум ам.долларт хүрсэн нь 2009 оны үеийнхээс 4.5 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2021 оны байдлаар Монгол–Хятадын худалдааны эргэлтийн хэмжээ 10.1 тэрбум ам.долларт хүрснээр Монгол Улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн


хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрт тусгасан эдийн засгийн хамтын ажиллагааны зорилт биелсэн. Хоёр улсын хооронд эдийн засгийн харилцаа хөгжихийн хэрээр хөнгөлөлттэй зээл буюу буцалтгүй тусламжид хамаардаггүй, харин эдийн засгийн харилцаанд хамаарах олон төрлийн зээл бий болов. Тухайлбал, өрийн бичиг, богино хугацаат зээл, валютын своп хэлцэл, хөрөнгө оруулалтын зээл, урт хугацаат зээл зэргийг дурдаж болно. Хятадаас авсан энэ төрлийн зарим зээлийг 2000 оны байдлаар доор жагсаавал:

- Засгийн газрын өр 746 мянган \$
- Богино хугацаат зээл 64 мянган \$
- Бондын өрийн бичиг 149.8 мянган \$
- Хөрөнгө оруулагчийн зээл 354.9 мянган \$
- урт хугацаат зээл нь 202 мянган
- бусад салбарын зээл богино хугацаат 33.8 мянган \$
- урт хугацаат өр 52 мянган \$

Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам¹⁸

График 7. Монгол Улсын нийт гадаад өр (2015-2023 он)

Хэмжих нэгж: сая.ам.доллар



Эх сурвалж: “Монгол Улсын нийт гадаад өр”, Үндэсний статистикийн хороо, https://www.1212.mn/mn/statistic/statcate/573058/table-view/DT_NSO_0700_028V3

Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн өсөлт 2018 онд 22,3 хувь, 2019 онд 14,3 хувь, 2020 онд 28,9 хувь, 2021 онд хувь, 2022 онд хувиар тус тус өссөн байна¹⁹.

2022 оны байдлаар БНХАУ-аас авсан хөнгөлөлттэй зээлийн хэмжээ 1.7 тэрбум америк долларт хүрсэн бөгөөд Монгол улсын нийт гадаад өрийн 4.8 хувийг

¹⁸ Эдийн засаг, хөгжлийн яам, БНХАУ-аас Монгол Улсад үзүүлж буй зээл, тусламж, Улаанбаатар, 2022, танилцуулга. Холбоос: https://www.mongolbank.mn/file/a0e0b19a1d9077d161459638a368078f/files/20220621_05.pdf. Хамгийн сүүлд: 2024.02.03.

¹⁹ Төрийн аудитын байгууллага, Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүн, УБ., 2022 он, <https://www.audit.mn>

тус тус эзэлж байна.

*Хүснэгт 3. БНХАУ-ын санхүүжилтээр хэрэгжиж буй буцалтгүй
тусламжийн төслүүд*

Төслийн нэр	Төлөв	Эхлэх	Дуусах
Үндэсний урлагийн их театрын барилга барих төсөл	Шинэ	2024	2026
Монгол Улсын Боомтын гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн төсөл	Шинэ	2022	2025
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор барих төсөл	Шинэ	2022	2025
Хилийн боомтын дэд бүтцийн төсөл	Шилжих	2019	2024
1008 айлын түр суурьшуулах орон сууцын төсөл	Шилжих	2019	2024
Буянт-Ухаа спортын ордны боломж ашиглалтыг нэмэгдүүлэх төсөл	Дуусах	2019	2023
Ерөнхийлөгч нарын спорт цогцолбор барих төсөл	Хэлэлцээрт	2024	2026

Эх сурвалж: Сангийн яам,

Холбоос: <https://mof.gov.mn/article/entry/mnchinacooperation-> .

Хамгийн сүүлд: 2024.02.03.

2017 онд Хятадын талын хөнгөлөлттэй зээлээр Баянхонгор аймгийн 129.4 км авто зам, Завхан аймгийн 114 км , 67 км зэрэг Монголын баруун аймгуудын авто замын төслийн ажлыг эхлүүллээ. Төслийн ажил гүйцэтгэгдсэнээр Монголын баруун бүсийн аймгуудын зам харилцааны нөхцөл ихээхэн сайжирч, тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд нөлөөлөхүйц баталгаа болох болно.²⁰

6-р сарын 21-нд Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын шав тавих ёслол Улаанбаатар хотын баруун хэсэгт боллоо. Энэхүү төсөл нь Хятадын талын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлсэн бөгөөд агаарын шугамын нийт урт ойролцоогоор 250 км-ын Монголын анхны 330 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам юм. Төслийг БНХАУ-ын «ТВЕА» групп гүйцэтгэсэн. Уг төсөл ашиглалтад орсноор Улаанбаатар хотоос Монголын өмнө хэсгийн говийн уурхайн бүсийг цахилгааны шугамаар хангана. Энэхүү төсөл нь Монголын өмнө бүсийн эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой юм.²¹

2017 оноос хойш Хятадын тал Монголд тусламж үзүүлэх амлалтаа үргэлжлүүлэн хэрэгжүүлж, тусламжийн төслүүд амжилттай урагшилсан. Тухайлбал, Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн төв барих төслийн ажил ажилттай явагдаж, үндсэн барилга баригдаад байна. Түүнчлэн сургууль цэцэрлэгийн, гэр хорооллын дахин төлөвлөлтийн, хилийн боомтын дэд

²⁰ 2018 оны Хятад, Монголын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны онцлох 10 мэдээ, БНХАУ-аас Монгол Улсад суух ЭСЯ-ны цахим хуудас, Хаяг: mn.china-embassy.gov.cn. Холбоос: http://mn.china-embassy.gov.cn/mn/zmgx/201812/t20181225_1662113.htm . Хамгийн сүүлд 2024.02.03.

²¹ 2018 оны Хятад, Монголын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны онцлох 10 мэдээ, БНХАУ-аас Монгол Улсад суух ЭСЯ-ны цахим хуудас, Хаяг: mn.china-embassy.gov.cn. Холбоос: http://mn.china-embassy.gov.cn/mn/zmgx/201812/t20181225_1662113.htm . Хамгийн сүүлд 2024.02.03.

бүтцийн бүтээн байгуулалтын зэрэг төслүүд тогтвортой урагшилж мөн тусламжийн бараа материалыг хэдийн Монголын талд хүлээлгэн өгсөн юм.²²

Хүснэгт 4. БНХАУ-ын санхүүжилтээр хэрэгжиж буй зээлийн төслүүд

Төслийн нэр	Төлөв	Эхлэх	Дуусах
Дэд бүтэц төсөл-Туул, Сэлбэ голын орчныг сайжруулах дэд бүтцийг хөгжүүлэх төсөл	Хэлэлцээрт	2023	2025
Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих техникийн шинэчлэл хийх төсөл	Хэлэлцээрт	2022	-
Өрсөлдлөх чадвартай дээд боловсрол төсөл	Хэлэлцээрт	2023	2025
Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулах төсөл	Хэлэлцээрт	2023	2025
Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл	Хэлэлцээрт	2020	2025
Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл	Шилжих	2020	2025
Дэд бүтэц төсөл-Нүхэн гарц төсөл	Шилжих	2021	2025
Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц	Шилжих	2021	2028
Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9км авто зам барих төсөл	Дуусах	2019	2023
Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 67км автозам барих төсөл	Дуусах	2019	2023

Эх сурвалж: Сангийн яам,

Холбоос: <https://mof.gov.mn/article/entry/mnchinacooperation->

Хамгийн сүүлд: 2024.02.03.

Хятадын гадаад тусламжийн дөрвөн нөхцөл ба Монгол

Хятадын гадаад тусламжийн хэмжээ нь 2022 оны байдлаар 4.8 тэрбум долларт хүрч өссөн бөгөөд Ази, Африкийн бага, дунд орлоготой болон буурай хөгжилтэй улсуудад ихэвчлэн зориулагдаж, үүний багахан хувь нь Монгол Улсад ноогдож байна.

Хятадын гадаад тусламжийн бодлогод улс төрийн, шууд бус, үүсмэл, солбицсон зэрэг тодорхой нөхцөлүүд тавигддаг. 1949 оноос хойш Монголд үзүүлж ирсэн Хятадын гадаад тусламжийн тоймоос үзэхэд барилга, дэд бүтцийн салбарт чиглэх хандлагатай байж иржээ. Энэ нь Монголын барилга, дэд бүтцийн нөхцөл муу, томоохон хөрөнгө оруулалт шаарддагтай холбоотой юм. Энэ хандлага цаашид ч үргэлжлэх, өсөн нэмэгдэх төлөвтэй байна.

Улс төрийн нөхцөлийн хувьд, тусламж, зээл авахын тулд тусламж хүлээн авагч улс нь нэг Хятадын зарчмыг баримтлах ёстой бөгөөд Тайваньтай албан ёсны

²² 2018 оны Хятад, Монголын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны онцлох 10 мэдээ, БНХАУ-аас Монгол Улсад суух ЭСЯ-ны цахим хуудас, Хаяг: mn.china-embassy.gov.cn. Холбоос: http://mn.china-embassy.gov.cn/mn/zmgx/201812/t20181225_1662113.htm. Хамгийн сүүлд 2024.02.03.

харилцаатай байж болохгүй. Монгол Улс “Нэг Хятад” зарчмыг дэмждэгээ удаа дараа мэдэгдэж ирсэн учир энэ нөхцөл нь ямар нэг хүндрэл үүсгэдэггүй. Тухайлбал, Монгол Улсын ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн айлчлалын үеэр 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Бээжин хотод гаргасан тус хоёр улсын хамтарсан мэдэгдэлд “Монголын тал “Нэг Хятад”-ын бодлогыг тууштай баримталж, Тайвань, Хонконг, Шинжаан, Төвөдийн талаарх Хятадын байр суурийг дэмждэгээ дахин нотлов” хэмээсэн бий.

Хятадын тусламжийг хүлээн авагч аливаа улс Хятадын хөдөлмөрийн нөөцийг ашиглахыг зөвшөөрч, Хятадын аж ахуйн нэгжүүдийн тогтоосон дүрэм журмыг дагаж мөрддөг. Тэгвэл Хятадын компаниуд Монгол дахь Хятадаас үзүүлж буй гадаад тусламжийн төслүүдийн үндсэн гүйцэтгэлийн ихэнх хэсгийг хариуцдаг. Тухайлбал, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатар хотын Яармагийн гүүрийг шинэчлэн барих ажлыг Хятадын Төмөр замын 12-р дугаар групп компани хариуцан гүйцэтгэж байв.

Хятадын тусламжийг хүлээн авч байсан улсуудын дунд стратегийн зарим салбарт эдийн засгийн талаар Хятадаас ихээхэн хамааралтай болсон тухай зарим кейс бий. Хятадын гадаад тусламжийн нөлөө Монголын эрдэс баялаг, банк санхүү, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо зэрэг стратегийн салбаруудад харьцангуй бага үүрэгтэй байсан хэдий ч сүүлийн жилүүдэд Монголын эрчим хүч, хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбар дахь Хятадын гадаад тусламж нэмэгдэж байна.

БНХАУ-ын зээл нь ихэнхдээ урт хугацааны дараа үр дүнгээ үзүүлдэг зам, гүүр зэрэг дэд бүтцийг хөгжүүлэх төслүүдэд хөрөнгө оруулалт хэлбэрээр шингэдэг. Ингэхдээ Засаглалын хувьд тогтворгүй, хөгжиж буй орнуудад олгогддог. Харин зээлийн энэ таатай нөхцөлийг тухайн төслийг зөвхөн Хятадын компаниуд болон ажилчид гүйцэтгэнэ гэх заалт дагалддаг. Өөрөөр хэлбэл, зээлсэн мөнгө эргээд эзэндээ очдог бөгөөд зээлдэгч талд зөвхөн дэд бүтцүүд, зайлшгүй төлөх нөхцөлтэй, эдийн засгийн бодит нөөц бололцооноос нь үлэмж хальсан их хэмжээний өрийн хамт үлддэг. Гэвч Монгол Улсын тухайд хөнгөлөлттэй зээлийн бодит ашиглалт тун бага хувьтай байгаа тул Хятадын хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлттэй холбогдож үүсэх эрсдэл ойрын үед бага байна.

Хятадын аж ахуйн нэгжүүд хүлээн авагч улсдаа тусламж, зээлийн хэлэлцээрээс гадуур нэмэлт шаардлагыг хөшүүрэг болгох боломжийг Хятадын банкнуудын санхүүжилт олгодог. Монголд үзүүлж буй Хятадын гадаад тусламжууд нь Монгол дахь Хятадын эдийн засгийн нөлөөлөлттэй холилдож, салбар дундын хөшүүрэг үүсгэх боломжтой. Тухайлбал, хөнгөлөлттэй зээлийн ашиглалт, гүйцэтгэл нэмэгдсэн нөхцөлд хөнгөлөлттэй зээл ба валютын своп хэлцлийн хооронд хамаарал үүсэж, улмаар хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт нь валютын своп хэлцлээс шууд хамаардаг болон хувирах магадлал бий.

Хятадаас Монголд үзүүлж буй гадаад тусламжийн улс төрийн болзол нь Монголын хувьд эрсдэл үүсгэх магадлал бага юм. Харин Монгол Улсын стратегийн салбарууд дахь Хятадын нөлөөнөөс үүсэж болзошгүй үүсмэл нөхцөлүүд, ажиллах хүчний болзол, экспорт, түүхий эдийн худалдаа, арилжааны зээл зэрэг эдийн засгийн

бусад салбарын нөлөөнөөс гаралтай хөшүүргийн шинжтэй нөхцөлүүд тулгарах эрсдэл ажиглагдаж байна. Ялангуяа Хятадын эдийн засгаас, илүү тодорхой хэлбэл Хятадын тодорхой аж ахуйн нэгжээс шууд хамааралтай нүүрсний экспорт зэрэг салбаруудад гадаад тусламжийн нэмэлт нөхцөл тойруу замаар үүсэх эрсдэл оршиж байна.

ДҮГНЭЛТ

Хятад улсын гадаад тусламжийн бодлого анх ганцаардлаас салж, олон улсын хамтын нийгэмлэгт нэгдэх зорилготой байсан бол ХХI зууны эхэн үеэс бодлогын хандлага, цар хүрээний хувьд илүү системтэй, идэвхтэй болсон гэж хэлж болно. Сүүлийн жилүүдэд гадны эрдэмтэн, судлаачид Хятад улс гадаад тусламжийн бодлогын хүрээнд улс төрийн, шууд бус, үүсмэл, солбицсон зэрэг тодорхой нөхцөлүүдийг тавих болсон нь судалгаанаас харагдаж байна. Харин Монгол Улсын төр өрийн хавхны талаар идэвхтэй бичиж, сэрэмжлүүлж буй судлаач, сэтгүүлчдийн санал, бодлыг анхааралтай сонсохын хажуугаар үүнээс гадна гадаад тусламжийн харилцаа, эдийн засгийн харилцаа хоёрыг, хөнгөлөлттэй зээл болон арилжааны зээл хоёрыг хольж хутгахгүй байх, хэрэв энэ хоёр нь холилдсон нөхцөлд Хятадын солбицсон болзолтой тулгарах магадлалтайг бид анхаарч байх учиртай. Өөрөөр хэлбэл зөвхөн хөнгөлөлттэй зээлээс шалтгаалж эрсдэл үүсэх магадлал бага бол харин Хятадын эдийн засгаас шууд хамааралтай тодорхой салбаруудад Хятадын гадаад тусламжийг хүлээн авсан нөхцөлд тухайн аж ахуйн үйл ажиллагаанд оролцож буй Хятадын талын харилцагчдаар дамжуулан урьдчилан тооцоолоогүй нэмэлт болзол, Хятадын салбар хоорондын дотоод хамаарлаас гаралтай хөшүүргийн нөлөө үүсэх бодитой эрсдэл оршиж байна.

Эдгээр эрсдэл оршин байгаа явдал мэдээж олон шалтгаантай байж болох бөгөөд үүний дотор Монгол улсаас өөрөөс нь хамаарах нөхцөл нь манай улс өрийн удирдлагын талаар Засгийн газраас баримтлах бодлогоо өнөөг хүртэл батлаагүй байгаа явдал юм. Өрийн удирдлагын талаар Засгийн газраас баримтлах бодлого нь тухайн улсад гадаад тусламжийн гаралтай болзошгүй эрсдэлийг бууруулах суурь баримт бичиг билээ. Иймээс УИХ-аас Өрийн удирдлагын тухай хуулийн 7.1.4-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж, Засгийн газрын зээлийн талаар төрөөс баримтлах бодлогыг цаг алдалгүй боловсруулж батлах шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Өрийн удирдлагын тухай Монгол Улсын хууль. <https://legalinfo.mn/mn/detail/10933>
2. Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 08-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл. <https://www.parliament.mn/files/593e70da08bd4782ac84d74e7981e46c/?d=1>
3. Найрамдал, хамтын ажиллагааны нэгэн жаран, Бээжин, 2009.
4. Монгол-Хятадын харилцаа жарнаас жаранд. Улаанбаатар. 2009.
5. Жоу Энълай ба Монгол орон, Улаанбаатар: Архивын Ерөнхий Газар, 2014.
6. Болормаа, Г., Монгол-Хятадын иж бүрэн стратегийн түншлэл дэх зээл, тусламжийн асуудал - // Монгол, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны явц, сорилт, боломж”, Улаанбаатар, 2015.

7. Эдийн засаг, хөгжлийн яам, БНХАУ-аас Монгол Улсад үзүүлж буй зээл, тусламж, Улаанбаатар, 2022, танилцуулга. Холбоос: https://www.mongolbank.mn/file/a0e-0b19a1d9077d161459638a368078f/files/20220621_05.pdf. Хамгийн сүүлд: 2024.02.03.
8. Оюунчимэг, Ц. Зээл тусламжийн бодлого хаашаа чиглэж байна вэ, Ерөнхий сайд аа? Zindaa.mn, 2017. Холбоос: <https://news.zindaa.mn/23b4>. Хамгийн сүүлд 2024.02.03.
9. 2018 оны Хятад, Монголын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны онцлох 10 мэдээ, БНХАУ-аас Монгол Улсад суух ЭСЯ-ны цахим хуудас mn.china-embassy.gov.cn. Холбоос: http://mn.china-embassy.gov.cn/mn/zmgx/201812/t20181225_1662113.htm. Хамгийн сүүлд 2024.02.03.
10. Кашин Василий Борисович, Королев Александр Сергеевич, Пятачкова Анастасия Сергеевна Китайская политика помощи зарубежным странам: основные принципы и направления // Китай в мировой и региональной политике. История и современность. 2017. №22. URL: <https://cyberleninka.ru/article/n/kitayskaya-politika-pomoschi-zarubezhnym-stranam-osnovnye-printsipy-i-napravleniya> (дата обращения: 03.02.2024).
11. Батхүү.И, “Монгол Улс, БНХАУ-ын хөгжлийн хамтын ажиллагааны оргил үе тохиож байна”, Мөнгө санхүү, баялаг сэтгүүл, УБ.,2022 он.
12. Болормаа, Г, “Монгол-Хятадын иж бүрэн стратегийн түншлэл дэх зээл, тусламжийн асуудал”. Монгол, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны явц, сорилт, боломж. Улаанбаатар, 2015.
13. Johnston, Lauren, and Marina Rudyak. “China’s ‘Innovative and Pragmatic’ Foreign Aid: Shaped by and Now Shaping Globalisation.” In *China’s New Sources of Economic Growth: Human Capital, Innovation and Technological Change*, edited by Lauren Johnston, Ligang Song, Ross Gard Cai Fang, 2:431–52. ANU Press, 2017. <http://www.jstor.org/stable/j.ctt1trkk3v.26>.
14. Алтантөгс.Н., “Хятадаас 1956-1960 онд Монголд зориулж олгосон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн үр дүнг шинжлэх нь”, [tps://esan.mn/p/research/investmen](https://esan.mn/p/research/investmen)
15. Varrall, Merriden. “Chinese Views on China’s Role in International Development Assistance.” *Pacific Affairs* 86, no. 2 (2013): 233–55. <http://www.jstor.org/stable/43590660>.
16. Varrall, Merriden. “Chinese Worldviews and China’s Foreign Policy.” *Lowy Institute for International Policy*, 2015. <http://www.jstor.org/stable/resrep10139>.
17. В.Б. Кашин, А.С. Королев, А.С.Пятачкова “Китайская политика помощи зарубежным странам: Основные принципы и направления”, kitayskaya-politika-pomoschi-zarubezhnym-stranam-osnovnye-printsipy-i-napravleniya (1).pdf
18. Conditionality in China’s Aid Model. <https://carnegieendowment.org/2012/01/10/conditionality-in-china-s-aid-model-event-4024>
19. Д, Шүрхүү. 2007. “БНХАУ-ын софт хүч чадлын өсөлт, түүний олон улсын үр нөлөө”. *Journal of International Studies* 4 (4):29-36. <https://doi.org/10.5564/jis.v4i4.2093>.
20. Г.Урантуяа, Монгол, Хятадын харилцааны шинэ цагийн түүх, montsame.mn, 2022, Холбоос: <https://www.montsame.mn/en/read/301790>. Хамгийн сүүлд: 2024.02.03.